



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20.10 оны 03 сарын 14-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Говь ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл, Компанийн дүрмийн 6.2.7.3, 6.2.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2020 оны 4 сарын 24-ний Баасан гарагийн 10:00 цагт** “Corporate Hotel and Convention Centre”-н концертын танхимд хуралдуулсугай. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 4 сарын 3-ны өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2020 оны 3 сарын 19-ний өдөр хүргүүлэн, хурлын товыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2020 оны 3 сарын 19 болон 4 сарын 3-ны өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2020 оны 3 сарын 24-ний өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 3 дугаар хавсралтаар баталсугай.



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 14 ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Долоо. Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна компанийн шуудангийн хаягаар болон брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2020 оны 4 сарын 20-ны өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 5 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэх, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 6 дугаар хавсралтаар баталсугай.

Арав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга Н.Сүрэнрагчаа-д даалгасугай.

Комиссын дарга: Тэргүүн дэд захирал Н.Сүрэнрагчаа
Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа
Хүний нөөц, захиргаа хариуцсан захирал Ч.Солонго

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

У.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ


А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 03 сарын 11-ний өдрийн хурлын
07-р тогтоолын 1-р хавсралт



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Говь ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. 2018 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2019 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны ажлын тайланг танилцуулах
5. Компанийн Дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг батлах
6. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг батлах

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 02 сарын 17-ний өдрийн хурлын
07-р тогтоолын 2-р хавсралт



**ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТАНИЛЦАЖ
БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ
ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2020 оны 3 сарын 24-ний өдрөөс эхлэн Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354), Компанийн цахим хуудас (www.gobi.mn), мөн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж хурлын материалтай танилцаж болно.
2. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Компанийн санхүүгийн жилийн тайлан
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
 - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
 - Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх
/Тооллогын комиссын дарга Н.Сайнзул/ 3 минут
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 3 минут
3. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа/ 3 минут
4. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:
 - 4.1. Компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
/Тэргүүн дэд захирал Н.Сүрэнрагчаа/ 10 минут
 - 4.2. ТУЗ-өөс компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
 - 4.3. 2018 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2019 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа/ 3 минут
 - 4.4. ТУЗ-ийн 2019 оны ажлын тайланг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
 - 4.5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах талаар танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа/ 3 минут
 - 4.6. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг товч танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа/ 3 минут
5. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт Хүн тус бүр 3 минут
6. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, шүүмжлэл: Хүн тус бүр 3 минут
7. Саналын хуудсаар санал авах 10 минут
8. Цайны завсарлага 15 минут
9. Санал хураалтын дүнг нэгтгэн, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах 5 минут
10. Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа/ 3 минут

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.



“ГОВЬ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШГЧДИЙН
ЭЗЭЛЖИТ ХҮҮРЛЫН САНАГАВАХ ХУУДАС

“Говь” ХК-ийн хувьцаа эзэмшэгчдийн хэлэлцэтгэлийн үеэр, 2020 оны 04 сарын 24-ний өдөр
Эсэх үеэр: 10:00 цаг
Байршил: Corporate and Convention Centre, конференц тохиолдол хурхалдаг.

Хуваацаа эзэмшигчийн овог нэр мсгийн
Регистрийн дугаар
Эзэмшигч буй хуваацааны тоо төрөл мсгийн

№	Шийдлэр гаргаж, батлах асуудлын нэр	Хурлаас гаргах шидвэрийн тоолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түгээлсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Команийн үйл ажлалгааны болов сэлүүгийн байнгын, галаарх ТУЗ-ийн дүрмэтийг батлах	ТУЗ-ийн дүрмэтийг Ойрсдийн нөөц боловсроог бүрэн дүрмэтийг анхлан амжилсан				
2	Команийн дүрмэ өөрчлөлт оруулах асуудлыг батлах	Өөрчлөлтийг оррулах				

2020 оны ...-р сарын ...-ны өдөр

Хуваацаа эзэмшигчийн гарын үсэг

Тогтоолын хэмжээ: Батлах хэсэг:

Хуваацаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар:


Саналын хуудсыг хүчингэд тоонон тоолсон эхс: Тийм ☐ Үгүй ☐

Саналын хуудсыг хүчингэд тоолсон бол шалтгаан:

САНАГАВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САЛАМЖ

1. Санал авах хуудсыг дараах заарвал дагуу бөглөнө.
 - Саналын хуудсыг зөвхөн нэгтэй сонгож (✓) тэмдэг тавина.
Жишээ нь: зөвшөөрсөн бол “зөвшөөрсөн” гэсэн үгэнд (✓), татгалзсан бол “татгалзсан” гэсэн үгэнд (✓), түгээлсэн бол “түгээлсэн” гэсэн үгэнд (✓) тэмдэг тавина.
 - Хэрвэ татгалзсан буй асуудлын шийдвэрийн төслийг татгалзсан саналтай байгаа бол “Таны өгөх санал” гэсэн үгэнд үг асуудлыг хүрсэн шийдвэрлэх саналтай байгаагаар бичнэ.
 - Зөвшөөрсөн, баталсан, (✓)-ээс өөр тэмдэгтээс хэрэглэсэн болон хэв нэм саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тоолно.
2. Хэрвэ татгалзсан хуудсуг урьдчилан саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, саналаа авах хуудсанд саналаа тэмдэгтэж, оройн хуралдагч брокер дилерийн компаниаа хүргэх эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, “Говь” ХК хэлээр 2020 оны 04 сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.
3. Хэрвэ татгалзсан өөр хүснэгт ирүүлүүлэн өгөх бол төлөөлөгч хүндээ итгэмжлэл бичиж өгнө, нотариагтар баталгаажуулсан байна.

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 03 сарын 14-ний өдрийн хурлын
07-р тогтоолын 1-р хавсралт



GOBI
MONGOLIAN COMPANY

"ГОВЬ" ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЗЭЖИТ ХҮРЛЫН САНААГАХ ХҮҮЦАС

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн үзэмжт хурлын өдөр: 2020 оны 04 сарын 24-ний өдөр
Эхэлх цаг: 10:00 цаг
Байршил: *Supervise Hotel Convention Centre, conference hall* хуралдана.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр
Регистрийн дугаар
Эзэмшигч буй хувьцааны тоо төрөл энгийн

ТУЗ-ийн гишүүнээр нэр дэвшигчдийг батлахыгх. (Хавсгал: дүрмийн өөрчлөлт)

Нэр дэвшигчид өгөх
хуульчилсан санхүүгийн тоо


Санах: ТУЗ-ийн хуралт бүс нийтлүүлсэн өгөг

1. Мягсарын БАЯР
2. Дамбын ГЭРЭЛМАА
3. Балдасгийн НАНДИН-ЭРДЭНЭ
4. Алтангэрэлийн ЖАРГАЛМАА
5. Тасгийн КАМБЭ

Санах: ТУЗ-ийн ердийн нийтлүүлсэн өгөг

1. Цэлэгийн БААТАРСАЙХАН
2. Жавзгалсгорын ОЮУНЧИМЭГ
3. Хялдоо САВАДА
4. Доржсэлэгийн ХУЛАН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 03 сарын 14-ний өдрийн хурлын
07-р тогтоолын 4-р хавсралт



2020 оны ...-р сарын ...-ны өдөр

/Хэвлэл мэдээллийн эх/

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4 сарын 24-ний өдрийн 10:00 цагт “Corporate Hotel and Convention Centre”-н концертын танхимд болох тул хувьцаа эзэмшигч та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2020 оны 4 сарын 3-ны өдөр

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Говь ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. 2018 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2019 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны ажлын тайланг танилцуулах
5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг батлах
6. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг батлах

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2020 оны 3 сарын 24-ний өдрөөс эхлэн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд Говь ХК-ийн төв байранд байрлах ТУЗ-ийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс өөрийн харилцдаг брокер, дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер дилерийн компанидаа өгөх эсвэл **Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК** хаягаар 2020 оны 4 сарын 20-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

Жич: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэл 2020 оны 4 сарын 24-ний 09:20-д эхлэн 10:00 цагт дуусах тул та бүхэн цагтаа цуглана уу.


Холбоо барих:

Хурал зохион байгуулах комиссын дарга Н.Сүрэнрагчаа
Утас: 7013-9977(1002)
Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа
Утас: 7013-9977(1193), 9411-8277
И-мэйл: boardsecretary@gobi.mn

Говь ХК-ийн албан ёсны хаяг, байршил:

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, “Говь” ХК
Утас: 7013-9977, Факс: 7014-3081

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2019 оны 08 сарын 17-ний өдрийн хурлын
07-р тогтоолын 6-р хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД БЭЛТГЭХ,

ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гүйцэтгэх ажлын утга	Эцсийн хугацаа	Хариуцах эзэн
А. ХУРЛЫН МАТЕРИАЛ БЭЛТГЭХ			
1	Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан илтгэл, холбогдох шийдвэрийн төсөл	III/19	Д.Гэрэлмаа Б.Нарантуяа
2	Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан бэлтгэж, хэвлүүлж, тараах	III/24	Б.Нарантуяа
Б. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ			
1	“Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх	III/19	Б.Нарантуяа
2	Хурлын зар мэдээ гаргах, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх	III/19, IV/3	Б.Нарантуяа
3	Хурлын танхимын бэлтгэл, зохион байгуулалт, тоног төхөөрөмжөөр хангах, хурлын хэвийн явцыг хангах	IV/24	Ч.Солонго
4	Хурал дээр хувьцаа эзэмшигчдэд танилцуулах компанийн үйл ажиллагааны талаарх танилцуулга бэлдэх	IV/17	Б.Цэнджав, Г.Сарнай, Б.Ангарагбаяр
5	Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд үзүүлэх компанийн талаарх видео, үзүүлэн бэлдэх	IV/17	Б.Цэнджав, Г.Сарнай, Б.Ангарагбаяр
6	Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээнд гарсан дэвшилттэй талыг харуулсан загварын үзүүлэн бэлдэх	IV/17	Б.Цэнджав, Г.Сарнай, Б.Ангарагбаяр
7	Саналын хуудсыг хэвлүүлэх	III/24	Б.Нарантуяа
8	Хурлын тэмдэглэл хөтлөх ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл хангуулах	IV/20	Ч.Солонго